



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар A/140

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Элэгний хорт хавдарын улмаас Турк улсад эмчлүүлэх шаардлагатай болж эмчилгээний зардал хүссэн иргэн Д.Батчулуунд 15,000,000 (Арван таван сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг дарга дансны "Иргэд байгууллагаас ирсэн санал хүсэлт шийдвэрлэх" зардлаас гаргаж шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л. Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН